



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 4117

Дэлгэрхаан сум

**Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Сумын төвийн нутаг дэвсгэрийн хэмжээнд намрын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд нийтийн эзэмшлийн газар, тоглоомын талбай, хайс хашаа, хогийн сав, аж ахуйн нэгж байгууллагуудын гадна талбай, хуваарьт газрын хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсугай.

2.Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, цэвэрлэгээг хамтран оролцох зохион байгуулах төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, шаардагдах шатахууны зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, их цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулахыг багийн Засаг дарга нарт, хог хаягдлын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх ажлыг зохион Аварга багийн Засаг дарга (Б.Мөнхолд)-д, их цэвэрлэгээний ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах, уриалга гарган зар хүргэх ажлыг хариуцан хэрэгжүүлэхийг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

4.Их цэвэрлэгээ зохион байгуулахад шаардагдах шатахууны зардалд 152,000 (нэг зуун тавин хоёр мянга) төгрөгийг хог хаягдлын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бодогч (О.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



2325010762

Засаг даргын 2015 оны 19 дүгээр сарын 15-ны
өдрийн 414 дугаар захирамжийн 2 хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Д.Батнасан	Засаг даргын орлогч
Гишүүд:	Д.Урангоо	Засаг даргын Тамгын газрын дарга
	Б.Бүжинлахм	2-р багийн Засаг дарга
	Б.Мөнхболд	3-р багийн Засаг дарга
	Д.Оюунчимэг	4-р багийн Засаг дарга
	Г.Батнасан	5-р багийн Засаг дарга
	Д.Баярмаа	Тархвар зүйч
	Х.Мөнхбат	Байгаль хамгаалагч
	П.Ангараг	Цаг уурын харуул
	Ш.Цэрэндулам	Ерөнхий боловсролын сургуулийн захирал
	С.Эрдэнэсүвд	Хүүхдийн цэцэрлэг
	Н.Доржнамжил	Соёлын төв
	О.Батбаяр	Эрүүл мэндийн төв
	Бат-Очир	Зэвсэгт хүчний 232-р анги
	Д.Шижирхүү	Хөдөө арлын цагаан нуур ХХК
	С.Ганхуяг	Мөнгөн бадрал ХХК
	Ц.Оюун-Эрдэнэ	Дэлгэрхангай ХХК
	Д.Цэрэнбуян	Энхдүүрэн баян ХХК

Засаг даргын 20²⁵ оны 10 дугаар сарын 15-ны
өдрийн 114 дугаар захирамжийн 2 хавсралт



ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Гудамж, зам талбай, голын ай сав газар, айл өрх аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн ажлыг эрчимжүүлэх	10.15-10.19	Байгаль хамгаалагч, багийн дарга нар, ААНэгжүүд, АБайгууллагын дарга нар
3	Цэцэрлэгт хүрээлэн, наадмын талбай, морь барианы талбайн хог цэвэрлэгээг хийлгэх	10.15-10.19	Аварга багийн Засаг дарга
4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна орчныг цэвэрлэх	10.15-10.19	ЕБСургуулийн захиргаа, СӨБ
6	Хийгдэж байгаа ажлын явцын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг сурталчлах	10.15-10.19	Аварга багийн дарга, Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
7	Нийтийн эзэмшлийн талбайг ААНэгж, албан байгууллагууд хувиарлсан талбайг цэвэрлэх	10.15-10.19	ААНэгж, АБайгууллгын ажилчид
8	Зөвшөөрөлгүй газар хог хаягдал хаясан тохиолдолд зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцох	Тухай бүр	БОХУБайцаагч

Засаг даргын 20.05.09 оны 09 дугаар сарын 15-ны
өдрийн 1/14 дугаар захирамжийн 3 хавсралт



ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Литр	нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Дт	л	50	3040	152,000
	Дүн	152,000			

